

"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК-ИЙН ХАГАС ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа</i>	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК, 9007001003, MSE:TNGR 95432111
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын хөрөнгийн бирж
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Хэвлэл мэдээлэл, контент үйлдвэрлэл
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	6,000,000
<i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал Хянасан: Санхүү эрхэлсэн захирал Д.Бат-Оюун Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ
1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>
	Санхүүгийн байдлын үзүүлэлт <u>Тайланг хавсаргав</u>
	Орлогын тайлан <u>Тайланг хавсаргав</u>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан <u>Тайланг хавсаргав</u>
	Мөнгөн гүйлгээний тайлан <u>Тайланг хавсаргав</u>
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>
	Тэнгэрлиг медиа Групп ХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүү байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон хагас жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан нь олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/
	Санхүүгийн үзүүлэлтүүд
	Ашигт ажиллагаа

3.2.	Хөрвөр чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table border="1"> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA)</td> <td>-0.01</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)</td> <td>-0.01</td> </tr> <tr> <td colspan="2">Өөрчлөлтийн хувь /оны эхээс/</td> </tr> <tr> <td>Нийт активын өөрчлөлт</td> <td>-3.2%</td> </tr> <tr> <td>Зээлийн багцын өөрчлөлт</td> <td>-100%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрөнгөд эзлэх хувь</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td> <td>80%</td> </tr> <tr> <td>Өр төлбөр/Нийт хөрөнгө</td> <td>19%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрвөх чадварын харьцаа</td> </tr> <tr> <td>Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/</td> <td>-</td> </tr> </table>	Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	-0.01	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	-0.01	Өөрчлөлтийн хувь /оны эхээс/		Нийт активын өөрчлөлт	-3.2%	Зээлийн багцын өөрчлөлт	-100%	Хөрөнгөд эзлэх хувь		Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	80%	Өр төлбөр/Нийт хөрөнгө	19%	Хөрвөх чадварын харьцаа		Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/	-
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	-0.01																					
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	-0.01																					
Өөрчлөлтийн хувь /оны эхээс/																						
Нийт активын өөрчлөлт	-3.2%																					
Зээлийн багцын өөрчлөлт	-100%																					
Хөрөнгөд эзлэх хувь																						
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	80%																					
Өр төлбөр/Нийт хөрөнгө	19%																					
Хөрвөх чадварын харьцаа																						
Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/	-																					
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	<p>Сошиал орчинд цаг үеийн түргэн шуурхай мэдээллийн үнэ цэн тасралтгүй нэмэгдэж, энэ талбарт үйл ажиллагаа явуулж буй вебсайт, сошиал багуудын тоо өссөөр байна. Энэ нь зөвхөн үзэлт болон хандалт төдийгүй зар сурталчилгаа, борлуулалтад ч нөлөөлж байна. Иймд ТэнГэр ТВ нь сошиал орчин дахь дижитал стратегиа дахин тодорхойлж, мэдээ мэдээллийг шуурхай хүргэр веб сувгийг хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэ нь хэрэглэгчдэд өөрсдийн хамгийн их цаг өнгөрүүлдэг платформоосоо үнэн зөв, баталгаатай эх сурвалж бүхий чанартаа агуулга хүлээн авах сонголтыг нэмэгдүүлнэ.</p> <p>Анрид Медиа нь зорилтот сегментүүдэд төвлөрсөн контент агуулгыг улам баяжуулж, илүү дэвшилтэт формат, бүтээлч шинж чанартай төрөлжсөн контентийн сувгаа нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.</p> <p>Цар тахал болон бусад гадаад нөхцөл байдлын улмаас Монгол Улсын хилээр импортлох бараа бүтээгдэхүүний эргэлт удааширч, гадаад валютын ханш өссөн зэрэг нь тоног төхөөрөмж, барилгын материал, түүхий эдийн үнэ өсөх нөхцлийг бүрдүүлсэн. Энэхүү үүссэн нөхцөл байдал нь ТэнГэрЛиг Медиа Группийн хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон төсөл болох Ори Студиосын бүтээн байгуулалтын ажилд нэлээдгүй сөргөөр нөлөөлсөөр байгаа хэдий ч бид боломж бололцоог эрэлхийлэн дээрх төслүүдийг зогсолтгүй үргэлжлүүлсээр байна. Үүний нэгэн илрэл нь Монгол ТВ нь өөрийн нэрийн бондыг хаалттай хүрээнд гаргаж амжилттай 5тэрбум төгрөг босгосон бөгөөд барилгын ажилд хөрөнгө оруулсан.</p>																				
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.																				

4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>
	<p>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.</p>
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>
	<p>2023 оны хагас жилийн хугацаанд нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</p>
6.	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл; Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</p>
	<p>2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭ-22/02 тоот тогтоолоор дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд томилсон. Үүнд:</p> <p>Ердийн гишүүд: Г.Уянга, Г.Бат-Эрдэнэ, Н.Мөнхнасан, Б.Золбоо, А.Ундрал, Ч.Батхүү Хараат бус гишүүд: Б.Наранзун, В.Ганзориг, Н.Цогт</p> <p>Компанийн эцсийн өмчлөгч: Гэр Интерьер Дизайн ХХК 36.6%</p> <p>Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид: Гэр Интерьер Дизайн ХХК 36.6% Ард санхүүгийн нэгдэл ХК 22.6% Л.Чинбат 11.5% Г.Бат-Эрдэнэ 11.5% Н.Мөнхнасан 10%</p> <p>2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 22/07 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар Г.Уянгыг томилсон.</p> <p>2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 21/09 тоот тогтоолоор Г.Бат-Эрдэнийг Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд өөрчлөлт ороогүй.</p> <p>ТУЗ нь 2023 оны хагас жилийн хугацаанд нийт 1 удаа биечлэн хуралдаж, эчнээ хэлбэрээр 4 удаа санал хураасан. Мөн компанийн Аудитын хороо; Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо; Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо нь тус бүр 1 удаа хуралдсан.</p> <p>Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн хувьд 2022 оны тайланд бичиж байсны дагуух өөрчлөлтүүдийг хийсэн.</p> <p>- Аудит хяналтын тогтолцоонд заасан “4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна” үүний дагуу 2022 оны хагас жилд, 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудитор оролцоогүй, дараагийн жилүүдээс хөндлөнгийн аудиторыг хуралд оролцуулж байх болно гэсэн тайлбар өгсөн ба 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа оролцож ХЭ-дэд мэдээлэл өгсөн.</p> <p>- Аудит хяналтын тогтолцоонд заасан “4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ” үүний дагуу 2022 оны хагас жилд Дотоод аудитын журмыг хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх болно гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2022 оны 10 сарын</p>

26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар тус журмыг баталсан.

- Эрсдэлийн удирдлагад заасан **“5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ири, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана”** үүний дагуу 2022 оны хагас жилд “ТУЗ нь дэргэдээ хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороотой бөгөөд, 4 гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хорооны даргаар ердийн гишүүн томилогдон ажилладаг, ээлжит ТУЗ-ийн хурлаар хорооны даргаар хараат бус гишүүнийг томилох болно” гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 17-ны өдрийн 23/04 тоот тогтоолоор хараат бус гишүүн В.Ганзоригийг хороон даргаар томилсон.

- Эрсдэлийн удирдлагад заасан **“5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина”** үүний дагуу 2022 оны хагас жилд “Ээлжит ТУЗ-ийн хурлаар комплайнсын хяналтын журмыг хэлэлцэн батлах болно” гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсан.

- Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулалд заасан **“6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална”** үүний дагуу 2022 оны хагас жилд Компанийн ашигт ажиллагаа тодорхой дүнд хүрсний дараа ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгохоор компанийн зүгээс санал гаргасан, ашигт ажиллагаанд хүрэх үед ХЭ-ийн ээлжит/ээлжит бус хурлаар цалин урамшуулал, олгох хэлбэр, давтамжийг хэлэлцэж батлах болно гэсэн тайлбар өгсөн ба 2023 оны 4 сарын 28-ны өдрийн ХЭ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг хэлэлцэж баталсан.

- Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулалд заасан **“6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана”** үүний дагуу 2022 оны хагас жилд ээлжит ТУЗ-ийн хурлаар цалин урамшууллын журамд эдгээр зүйл шалгууруудыг нэмж тусган батлах болно гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар Цалин урамшууллын бодлогыг баталсан.

-Оролцогч талуудын эрх ашигт заасан **“7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ”** үүний дагуу 2022 оны хагас жилд Ээлжит ТУЗ-ийн хурлаар бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгийг хэлэлцэн батлах болно гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын тавдугаар хавсралтаар оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг баталсан.

- Оролцогч талуудын эрх ашигт заасан **“7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана”** үүний дагуу 2022 оны хагас жилд 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаж өгөөгүй, 2022 онд үйл ажиллагааны тайландаа тусгаж өгөх болно гэсэн тайлбар өгсөн ба Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлогыг 2023 онд баталсан бөгөөд 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд тус мэдээллийг тусгаж ажиллах болно.

- Компанийн соёлд заасан **“8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна”** үүний дагуу 2022 оны хагас жилд ТУЗ-ийн ёс зүйн кодекст ёс зүйн зөрчлийг тайлагнах талаар тусгасан, уг журманд мэдээлэл өгсөн этгээд буюу “шүгэл үлээгч”-ийн нууцлалыг хадгалах, түүний нэр хүнд, цалин урамшуулал, ажлын байрыг нь хамгаалах зохицуулалтыг ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн нэмж тусгах болно гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар ТУЗ-ийн ёс зүйн кодексийн журамд нэмж оруулан баталсан.

- Компанийн соёлд заасан **“8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна”** үүний дагуу 2022 оны хагас жилд Ээлжит ТУЗ-ийн хурлаар ёс зүйн дүрэмд эдгээр зүйл заалтуудыг нэмж тусган батлах болно гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар нэмж баталсан.

- Хувьцаа эзэмшигчдийн эрхэд заасан “9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ” үүний дагуу 2022 оны хагас жилд Компанийн цахим хуудас дээр компанитай холбогдох боломжит социал хаягууд, цахим шуудан, санал хүсэлтийн хэсгийг холбосон, хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг боловсруулан ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална гэсэн тайлбар өгсөн ба ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг огноо:

Овог, нэр:

Албан тушаал “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал: Д.Бат-Оюун

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:.....

Овог, нэр:

Албан тушаал: “.....” ..К аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)



Handwritten signature in blue ink over the stamp.

Handwritten signature in blue ink: Л. Чувал

Handwritten signature in blue ink.